

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР**



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Булган сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: БУА-2026/13/НА-СТА-ТШЗ**

---

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт  
Утас: 70342580 Цахим хаяг: [Battsogtd@audit.gov.mn](mailto:Battsogtd@audit.gov.mn)  
Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас: 70342495 Цахим хаяг: [Enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn)  
Аудитор: З.Ганбаатар  
Утас: 70342495 Цахим хаяг: [ganbaatarz@audit.gov.mn](mailto:ganbaatarz@audit.gov.mn)

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Дүгнэлт



### БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.02.24

№

143

танай

ны №

т

БУЛГАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫГ ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
П.ЧАНЦАЛДУЛАМ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид байгууллагын үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

#### Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгааснаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн үндсэн хөрөнгийн хөдөлгөөн өөрчлөлт хийх талаарх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг арилгаагүй байна.

6326050102

### **Аудитын гол асуудал**

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 6.4, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1,646.9 нийт 1,653.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

### **Бусад асуудлын хэсэг**

Орхон сумын Засаг даргын тамгын газар нь 1 хөтөлбөр 8 арга хэмжээний хүрээнд 1,139.7 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, 1,081.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/Мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>		
Эргэлтийн хөрөнгийн дүн	148,324.0	145,708.9
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,246,001.0	5,686,080.5
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>4,394,325.0</b>	<b>5,831,789.3</b>
Нийт өр төлбөрийн дүн	4,946.1	3,091.5
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,389,378.8	5,828,697.8
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>4,394,325.0</b>	<b>5,831,789.3</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>		
Үйл ажиллагааны орлогын дүн	2,262,732.1	2,792,591.2
Үйл ажиллагааны зардлын дүн	1,246,561.9	1,353,272.2
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>1,016,170.2</b>	<b>1,439,319.0</b>
Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>1,016,170.2</b>	<b>1,439,319.0</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,888,204.27	4,389,378.84
Тайлант оны үр дүн	1,017,020.16	1,439,318.98
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>4,389,378.84</b>	<b>5,828,697.82</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,091,432	1,140,945
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,070,491	1,134,510
<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>20,941</b>	<b>6,435</b>
<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>20,958</b>	<b>6,435</b>
<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>16.80</b>	<b>-</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>		
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>1,172,812</b>	<b>1,088,094</b>
Урсгал зардал	1,172,812	1,081,659
Хөрөнгийн зардал	0	0
<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>1,172,811.70</b>	<b>1,125,798.00</b>
Улсын төсвөөс санхүүжих	1,172,811.70	1,125,798.00
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

### Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 46.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 2.9 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, 6.5 сая төгрөгийн 1 албан шаардлага, 27.0 сая төгрөгийн 2 зөвлөмж, 10.0 сая төгрөгийн төгрөгийн 1 алдаа залруулан ажиллаа.

#### 5.1 Төлбөрийн акт

- ✓ Тайлант онд шатахууны зардлаас 1,204.3 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй зарцуулсан,
- ✓ Багийн дарга нарт хээрийн хувцас 1,115.0 мянган төгрөгөөр худалдан авч өгсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг зөрчсөн,
- ✓ Төрийн албаны зөвлөлөөс ирсэн алба хаагчдад 584.0 мянган төгрөгөөр Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5, 15.1.7 заалтыг зөрчиж айраг худалдан авч өгсөн.

## 5.2 Албан шаардлага

- ✓ Тайлант онд 2 дугаар сургуулийн 1В ангийн ширээ, сандал шинэчлэхэд 17,500.0 мянган төгрөгөөр "Энх Алтун" ХХК-тай гэрээ байгуулсан ч сургуулийн боловсруулсан төсөлд заагдсан эд материалыг бүрэн нийлүүлээгүй.

## 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### Авлагын данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:1** Тайлант онд төсөл хөтөлбөрийн зардлаас нийт 7,000.0 мянган төгрөгийг уран бүтээлчдэд олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 3.5 дахь ” төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зардалд зарцуулахгүй байх.

**Илрүүлэлт:2** Төсөл хөтөлбөрийн зардлаас тайлант онд Цагдаагийн газарт шилжүүлсэн 20,000.0 мянган төгрөгийн зарцуулалтыг анхан шатны баримттай тулгахад Цагдаагийн албаны тухай хуулийн 94 дүгээр зүйлийн дагуу зарцуулаагүй.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7-д “энэ хуульд заасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага энэхүү стандартыг хэрхэн мөрдөж байгаад харилцагч санхүүгийн байгууллагатай хамтран хяналт тавих” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Эрх шилжүүлэн олгосон зардлын хэрэгжилтэд хяналт хийж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд Монголын Таеквондогийн холбоод мөрийн хөтөлбөрийн зардлаас 10,000.0 мянган	1	10,000.0			1		1	10,000.0				

төгрөгийн дэмжлэг үзүүлэхээс 3Д нөөц хөрөнгөөс зарцуулсан өглөгөөр тусгаагүй													
Дүн	1	10,000.0			1		1	10,000.0					

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Тайлант онд шатахууны зардлаас 1,204.3 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй зарцуулсан.	1	1,204.3	1	1,204.3									
Багийн дарга нарт хээрийн хувцас 1,115.0 мянган төгрөгөөр худалдан авсан.	1	1,115.0	1	1,115.0									
Төрийн албаны зөвлөлөөс ирсэн алба хаагчдад 584.0 мянган төгрөгөөр айраг худалдан авсан.	1	584.0	1	584.0									
Тайлант онд 2 дугаар	1				1	6,520.0							

сургуулийн 1В ангийн ширээ, сандаг шинэчлэхэд 17,500.0 мянган төгрөгөөр "Энх Алтун" ХХК-тай гэрээ байгуулсан ч сургуулийн боловсруулса н төсөлд заагдсан эд материалыг бүрэн нийлүүлээгүй												
Тайлант онд төсөл хөтөлбөрийн зардлаас нийт 7,000.0 мянган төгрөгийг уран бүтээлчдэд олгосон.	1						1	7,000.0				
Төсөл хөтөлбөрийн зардлаас тайлант онд Цагдаагийн газарт шилжүүлсэн 20,000.0 мянган төгрөгийн зарцуулалтыг анхан шатны баримттай тулгахад Цагдаагийн албаны тухай хуулийн 94 дүгээр зүйлийн дагуу зарцуулаагүй, зориулалт бусаар зарцуулсан	1						1	20,000.0				
Дүн	6	36,423. 3	3	2,903.3	1	6,520.0	2	27,000.0				